



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/220.

Хэрлэн сум

Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ,  
хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн бүтээгдэхүүн ажил үйлчилгээ, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын ажлыгтусгай графикийн дагуу жил бүрийн 4, 5, 9,10 дугаар саруудад зохион байгуулж байхыг Стандарт, хэмжил зүйн хэлтэс /Ч.Пүрэвдорж/-т үүрэг болгосугай.

2. Баталгаажуулалтын ажлыг явуулахад ажлын түр байр, хүн хүчний туслалцаа үзүүлж, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, хэмжих хэрэгслийг баталгаажуулалтад бүрэн хамруулж байхыг сумдын Засаг дарга, Тосгоны Захирагч нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт гавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Ж.Гантулга/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА